



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, түүний харьяа хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан автомашины (3 дахь) нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2.Автомашины худалдах доод үнийг 50 хувиар бууруулан, хавсралтаар тогтоосугай.

3.Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандоржид дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

3.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002105

D:\Huraldaanii material\2018 on\2018.06.26.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн  
 307 дугаар тогтоолын хавсралт

ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬАА ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэг дэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 467 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар								
1	Ниссан тийда, 74-92 УНЯ (арал-jn1bcac11z0050753)	2012	57811	37,000,000.00	21,583,333.27	15,416,666.73	7,000,000.00	3,500,000.00
	Дүн			37,000,000.00	21,583,333.27	15,416,666.73	7,000,000.00	3,500,000.00
2. Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс								
2	Ландкрузер-80, 81-84 АРА (арал-hdj810044038)	2010	223420	25,000,000.00	25,000,000.00	-	5,000,000.00	2,500,000.00
	Нийт дүн			25,000,000.00	25,000,000.00	-	5,000,000.00	2,500,000.00
							12,000,000.00 (арван хоёр сая)	6,000,000.00 (зургаан сая)